



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 4/279

Эрдэнэт


Шуурхай зөвлөгөөний дэг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, сумдын Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөний дэгийг хавсралтаар баталсугай.

2. Шуурхай зөвлөгөөний дэгийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /н. Соёлчхүү/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Шуурхай зөвлөгөөний дэг батлах тухай” аймгийн Засаг даргын 2016 оны 409 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



128

Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын  
18. ны өдрийн ~~12:49~~ дугаар захирамжийн хавсралт

## ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНИЙ ДЭГ

### Нэг. Зөвлөгөөнд бэлтгэх

1.1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, байгууллага, сумын Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн /цаашид "шуурхай зөвлөгөөн" гэх/-ийг зохион байгуулахад энэхүү дэгийг баримтална.

1.2. Шуурхай зөвлөгөөний бэлтгэл хангах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэн мэдээлэх /цахим г.м хэлбэрээр/ ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хариуцна.

1.3. Шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шаардлагатай тохиолдолд аймгийн Засаг даргын Тамгын газраас байгуулсан ажлын хэсэг болон Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс газар дээр нь шалгаж дүнг зөвлөгөөнд танилцуулна.

### Хоёр. Шуурхай зөвлөгөөн хийх

2.1. Шуурхай зөвлөгөөнийг долоо хоног бурийн "**ДАВАА**" гаригт 11.00 цагаас аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс болон сумдын Засаг дарга, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудыг батлагдсан жагсаалтын дагуу оролцуулан зохион байгуулна.

2.2. Шуурхай зөвлөгөөнд оролцох удирдах ажилтны нэрсийг аймгийн Засаг дарга батална.

2.3. Байгууллагын дарга нь хүндэтгэх шалтгаанаар /ээлжийн амралттай, албан томилолттой, өвчтэй, чөлөөтэй/ оролцож чадахгүй болсон үед аймгийн Засаг дарга, түүний орлогч нар болон Тамгын газрын даргад албан ёсоор бичгээр урьдчилан мэдэгдэж ажил орлох албан тушаалтныг зөвлөгөөнд оролцуулна.

2.4. Шуурхай зөвлөгөөнд оролцогсдын ирцийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ажилтан бүртгэнэ.

2.5. Шуурхай зөвлөгөөнд хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдийг зохион байгуулалттайгаар оролцуулах асуудлыг Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч хариуцна.

### Гурав. Шуурхай зөвлөгөөнд дор дурьдсан журмыг баримтална.

3.1. Шуурхай зөвлөгөөнийг аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагч удирдана.

3.2. Засаг даргын эзгүйд Засаг даргын орлогч, эсвэл Тамгын газрын дарга шуурхайг удирдана.

3.3. Шуурхай зөвлөгөөнөөр аймгийн хэмжээнд өмнөх шуурхайгаас хойш хийсэн ажлын товч мэдээлэл, ирэх 7 хоногт хийх гол ажил, цаг үеийн тулгамдсан асуудлуудын талаар мэдээлэл сонсож ярилцан Засаг даргаас үүрэг даалгавар өгөгднө.

3.4. Шуурхай зөвлөгөөнд дараах дарааллыг баримтална.

а/ Засаг даргын өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн тухай мэдээлэл 5-8 минут.

б/ Шуурхай зөвлөгөөний төлөвлөгөөнд орсон мэдээлэл. Тус бүр 3-5 минут.

Зөвлөгөөнд Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах 70353511 утсанд ирүүлсэн асуудал болон Хотын Захиргачийн алба, сумдын Засаг дарга нар мэдээлэл хийнэ. Шаардлагатай тохиолдолд аймгийн Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газрын даргаас өгсөн чиглэлийн дагуу бусад хэлтэс, агентлагуудын мэдээллийг сонсоно. Мэдээлэл хийх байгууллагын удирдлага урьдчилан 4 хоногийн өмнө санаалаа Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ. Шуурхай зөвлөгөөний төлөвлөгөөг 5 дахь өдөр аймгийн удирдлагад танилцуулж баталгаажуулна.

в/Шуурхай зөвлөгөөн даргалагчийн болон бусад удирдлагуудын асуулт, хариулт /тухай бүр 3 минутаас хэтрэхгүй байна/

г/Аймгийн Засаг даргаас тухайн хугацааны ажлыг дүгнэж, цаашид хийж гүйцэтгэх ажлын талаар үүрэг даалгавар өгнө.

Дөрөв. Шуурхай зөвлөгөөнд оролцогсдын хүлээх үүрэг

4.1. Шуурхай зөвлөгөөний талаарх мэдээллийг хэвлэл, мэдээллийн байгууллагууд иргэд, олон нийтэд хүргэнэ.

4.2. Шуурхай зөвлөгөөнд оролцогсод шуурхайн мэдээллийг хамт олон, ажил гардан хариуцах хүмүүст богино хугацаанд хүргэж хэрэгжүүлэх ажлыг биечлэн зохион байгуулж, хяналт тавих, хугацаанд нь мэдээлэх үүргийг аймгийн Засаг даргын өмнө хариуцахын зэрэгцээ тухайн шуурхай зөвлөгөөнөөр өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, үр дүнгийн талаарх мэдээллийг “БААСАН” гариг бүрийн 17<sup>00</sup> цаг гэхэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлнэ. Биелэлтийн мэдээллийг хугацаа хоцроосон болон албан ёсоор ирүүлээгүй талаар шуурхайд мэдээлнэ.

4.3. Шуурхай зөвлөгөөнийг хүндэтгэх шалтгаангүйгээр тасалсан, өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй албан тушаалтанд Монгол улсын Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

Мөн тухайн албан тушаалтан болон байгууллагынх нь ажлыг дүгнэх, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг тооцоход шуурхай зөвлөгөөнд хэрхэн оролцсон, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангасан талаарх асуудлыг үзүүлэлт болгон авч үзнэ.